



Энэхүү хичээлийн арга зүйн санаа нь ээлжит хичээлийг төлөвлөх, заах багшийн арга зүйг сайжруулах, сурагчдын сурлагын амжилтыг ахиулах, сургууль, багш нар сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ.

Суралцахуйн зорилт:

8.1в. Уншсан эхээс зохиогчийн мэдрэмж, сэтгэгдлийг ялган, учрыг тайлбарлах

Даалгавар 10

	№	Даалгавар	Оноо	Шалгуур	Гүйцэтгэлийн хувь	Гүйцэтгэлийн дундаж хувь
I	1	Д: 10а	1	Эхлэл хэсэгт: Шүлэгт хэзээ болсон, ямар үйл явдлын тухай гарч байгаа, түүнээс чи юу мэдэрсэн тухайгаа бичих	9,7	33
	2		2		53,8	
	3		3		35,1	
II	4	Д:10б	1		13,5	32,4
	5		2		62,4	
	6		3		21,3	
III	7	Д: 10в	1	Гол хэсэгт: Зохиогч шүлэгт мэдрэмжээ хэрхэн илэрхийлсэн, үүнээс чамд ямар сэтгэгдэл төрснийг баримтаар нотолж, дүрслэл ашиглаж, тайлбарлаж бичих	32,2	45,7
	8		2		59,2	
IV	9	Д: 10г	1		39,2	42,2
	10		2		45,3	
V	11	Д:10д	1	Төгсгөл хэсэгт: Өөрт төрсөн мэдрэмж, сэтгэгдэлтэйгээ холбон шүлгийн талаар дүгнэлт бичих	38,2	39,2
	12		2		40,2	
VI	13	Д:10е	1		42,9	36
	14		2		29,0	
VII	15	Д:10ё	1	Шүлгийг уншаад төрсөн мэдрэмж сэтгэгдэлээ 120-150 үгээр илэрхийлж бичих	55,9	55,9
Нийт						40,6

Даалгаврын зорилго:

Өөрт төрсөн мэдрэмж, санаа бодол, баримт мэдээ, үйл явдал, туршлагынхаа талаар бичих чадварыг илрүүлэх.

Сурагчдын гүйцэтгэлийн үр дүн

I, II хэсэгт сурагчид эхийн баримтыг шууд ашиглан бичсэн боловч үйл явдал болоод өөрт төрсөн мэдрэмжээ тодорхой гарган бичиж чадаагүй. Орон цаг болон үйл явдлын өрнөлийг бүрэн таниагүйн улмаас эхэд байгаа үг хэллэгийг шууд хуулбарлан бичсэн байна.

III, IV хэсэгт хэсэгт өөрт төрсөн сэтгэгдлээ сайн тусгаж оруулсан боловч баримт нотолгоо ашиглаагүй, үг сонголт бага байна. Зохиогчийн мэдрэмжээс улбаалан бичигдсэн үг хэллэг найруулгаас өөрт ямар мэдрэмж сэтгэгдэл төрснөө бичихдээ эхтэйгээ ойртуулаагүй хэт их сэтгэлийн өнгө аяс оруулж бичсэн.

V, VI хэсэгт дүрслэх хэрэглүүр, найруулга хангалтгүй байсан. Мөн эхийг уншаад бидний үеийн багачууд ийм байвал зохистой гэх мэт өөрийн сэтгэгдлээ санал болгон дүгнэн бичсэн нь бага байна.

VII хэсэгт үгийн тоо харгалзсан хувь 55,9 байгаа нь нийт сурагчдын үгийн сонголт, хэрэглээ бага байгааг харуулж байна.

ХИЧЭЭЛИЙН АРГА ЗҮЙН САНАА (12 МИН)

Үе шат / Танин мэдэхүйн үйл	Арга зүйн санаа
УНШИХ	<p>1. Эхийн утгыг ойлгож унших</p> <ul style="list-style-type: none"> • Нүдээр харж, чихээр сонсож, хамраар үнэрлэж, хэлээр амталж, биеэр хүртэж болохыг дүрслэн мэдрэмжээ илэрхийлсэн хэсгүүдийг тус бүрд ялгах • Мэдрэмжээ ямар үгээр илэрхийлснийг олж, ярилцах • Зохиогчийн мэдрэмжээс үүдэн төрсөн сэтгэгдлээ хуваалцах, ялгаатай сэтгэгдлүүдийг харьцуулах <p>2. Зохиогчийн мэдрэмж, сэтгэгдлийг ялгаж унших</p> <ul style="list-style-type: none"> • Уншиж, сонсож, харж байхад санаанд чинь өөр ямар нэг үйл явдал, тохиолдсон зүйл, болсон явдал, сонссон дуулсан юм санаанд чинь оров уу? • Чамд ямар сэтгэгдэл төрөв? /талархах, үзэн ядах, жигших, зэвүүцэх, итгэмээргүй .. г.м / • Ямар мэдрэмж төрөв? / ... юм шиг, ...юмтай адилхан, ... юм болж байсан шиг гэх мэт/
БИЧИХ	<p>1. Мэдрэмж, сэтгэгдэл, сэтгэл хөдлөлийг дүрслэн бичих хэлний арга хэрэглүүрийг сайн ажиглуулах нь үгийн баялгийг нэмэгдүүлэх, дүрслэн бичих чадварыг хөгжүүлэхэд тустай. Мөн хүүрнэмж эх бол тэр чигээрээ дүрслэл байдгийг танин мэдүүлэх нь чухал.</p> <ul style="list-style-type: none"> • Эхээс мэдрэмж илэрхийлсэн, сэтгэгдэл илэрхийлсэн хэсгийг ялгаж бичих • Мэдрэмж илэрхийлсэн болохыг батлахын тулд ямар мэдрэхүйгээр дамжиж илэрснийг тодорхойлох (Харагдах, сонсогдох, хүрэлцэх, амтлах, үнэртэх) • Сэтгэл хөдлөлийг ялган бичих • Сэтгэл хөдлөл, мэдрэмж, сэтгэгдэл 3 ямар ялгаатайг хүснэгтлэн ялгааг тэмдэглэж авах <p>2. Мэддэг болон мэддэггүйгээр ялгаж тэмдэглэх</p> <ul style="list-style-type: none"> • Хоёр ба түүнээс дээш эхийг харьцуулан унших замаар баримт ба сэтгэгдэл мэдрэмжийн ялгааг тодруулж тайлбарлах • Зохиогч санаагаа илэрхийлэхийн тулд ашигласан баримт нь түүний үзэл бодлоос ялгаатай болохыг ойлгох • Сэтгэгдэл мэдрэмж нь баримтаас яагаад ялгаатай болохыг тайлбарласан тодруулга бичих • Эхийн хэсгүүдийг ангилан ялгах, ганцаарчлан бодох, хосоор ажиллах, багаар саналаа нэгтгэх. Тухайлбал: “Бодох, хамтрах, хуваалцах” аргыг хэрэглэвэл үр дүнтэй. <p>Мэдрэмж, сэтгэгдлээ хөгжүүлэх</p> <ul style="list-style-type: none"> • Зохиол уншаад мэдрэмж сэтгэгдлээ илэрхийлэх • Зураг хараад сэтгэгдэл мэдрэмжээ илэрхийлэн бичих • Дуу, хөгжим сонсоод сэтгэгдэл мэдрэмжээ илэрхийлэн бичих • Хэн нэгний яриаг сонсоод сэтгэгдэл мэдрэмжээ илэрхийлэн бичих • Бодит хүмүүсийн амьдралын түүх замналыг уншаад сэтгэгдэл мэдрэмжээ илэрхийлэн бичих • Үзсэн харсан зүйлийнхээ талаар сэтгэгдэл мэдрэмжээ илэрхийлэн бичих • Хурал цуглаан уралдаан тэмцээнд оролцсон сэтгэгдэл, мэдрэмж, үнэлэлт, дүгнэлт ... гэх мэт • Болсон үйл явдлаас төрсөн мэдрэмж, сэтгэгдлээ илэрхийлэх • Бодит байдлаас төрсөн мэдрэмж, сэтгэгдлээ илэрхийлэн бичих

	<p>Зохиолыг анх уншихад ямар мэдрэмж, сэтгэгдэл төрж байсан ба зохиолоос танд хамгийн эхэлж санагдаж буй, эсвэл таны сэтгэлийг хөдөлгөсөн үг хэллэг болон шад бадгуудаас шууд санаанд орсон хэсгийг цаасан дээр тэмдэглүүлэх Үг хэллэг, дүр дүрслэл нь таны сэтгэлийг хэрхэн хөдөлгөж, юуг бодогдуулж, хувийн ямар дурсамж болоод туршлагыг тань сэргээн санагдуулж, юуг ухааруулсан талаар эргэцүүлэн ноорлон бичих</p> <p>Бичих санаагаа төлөвлөх</p> <p>Зохиолч энэ зохиолоороо дэвшүүлсэн гол асуудал юу байсныг тодорхойлох Энэхүү дэвшүүлсэн асуудлын хүрээнд илрүүлж буй зохиолчийн үзэл бодол хандлагатай хэр зэрэг санал нийлж байгаа талаар тунгаах</p> <p>Зохиолд ямар гүн гүнзгий юм уу эсвэл өвөрмөц содон санаа байсан, үүнээс танд ямар шинэ санаа урган гарч байгааг тунгааж, өөрийн санааг тэмдэглэн, мөн тайлбар бичих</p> <ul style="list-style-type: none"> • Санаагаа хурц тод илэрхийлэхийн тулд ямар үгсийг сонгон хэрэглэхээ бодох Ямар уран дүрслэл ашиглахаа төлөвлөж, жагсаах • Эцэст нь зохиолыг дүгнэн, энэ зохиолыг хамгийн тохиромжтой нэг үгээр тодорхойлж, бичвэртээ нэр өгөх <p>Бичиж эхлэх</p> <ul style="list-style-type: none"> • Хэдэн цогцолборт юуны тухай бичихээ төлөвлөж, ерөнхий зураглал, бүдүүвч гаргах • Өмнө бичсэн тайлбараа ашиглан бичих. • Дэвшүүлсэн асуудлын хүрээнд өөрийн байр суурийг илэрхийлэх, өөрийн байр суурийн үндэслэл, шалтгааныг танилцуулах, • Тэдгээр шалтгаануудыг учир зүйн дарааллын дагуу хэлхэж байрлуулах • Дэвшүүлж байгаа үндэслэлээ тоочин, жишээ баримтыг тодорхой гаргах • Өмнө бичсэн эшлэл тайлбарыг ашиглан санаагаа байрлуулахдаа холбоос үгийг хэрэглэх • Ноороглогсны дараа хянан сайжруулах, сийрүүлэн бичих
ЯРИХ -СОНСОХ	<p>Зохиол бүтээлийн тухай шинэ санаа гаргаж, дүрслэл ашиглан мэдрэмж сэтгэгдэл, үнэлэлт дүгнэлтээ илэрхийлэхийн тулд:</p> <ul style="list-style-type: none"> • Зохиолыг анх уншихад ямар мэдрэмж, сэтгэгдэл төрж байсан бэ? • Зохиолоос хамгийн анхаарал татсан сонин содон үг хэллэг, сонирхолтой хэсэг юу байсан бэ? • Зохиогч энэ зохиолоороо дэвшүүлсэн гол асуудал юу вэ? • Энэхүү дэвшүүлсэн асуудлын хүрээнд гаргасан зохиогчийн үзэл бодол хандлагатай чи хэр зэрэг санал нийлж байна вэ? • Зохиолыг хэрхэн дүгнэж байна вэ? • Ямар дүгнэлтэд хүрэв? Юуг ухаарч ойлгож авав? • Энэ зохиолыг хамгийн тохиромжтой нэг үгээр тодорхойл гэвэл юу гэж хэлэх вэ? гэх мэт асуултаар чиглүүлж сурагчдын үзэл бодлыг сонсоно. <p>Сурагчдыг сэтгэн бодуулах, дотоод агуулга утга санааг ойлгуулан тайлбарлуулахад чиглэсэн ЯАГААД? гэсэн асуултыг эх, уншсан материал, сонссон шүлгээс асууж, хариулт зөв эсэхийг анги нийтийн дунд үлдээвэл илүү үр өгөөжтэй.</p>
ҮНЭЛЭХ:	<p>Тодруулах асуулт асуух үед багш сурагчдын сонсоод ойлгох чадварыг давхар үнэлэх хэрэгтэй. Тодруулах асуулт асуухдаа заавал баримт, нотолгоон дээр тулгуурлахыг сануулаарай. Зарим сурагч сэдэвтэй огт хамааралгүй зүйл асууж, ярилцлага, хэлэлцүүлгийг өөр тийш нь эргүүлдэг. Тиймээс сурагчдыг зөвхөн сэдвийн хүрээнд яриа өрнүүлж сургахад анхаарна. Харилцан яриа бол хоёроос дээш хүний хооронд болдог. Зарим тохиолдолд сурагчид аль нэг нь зөвхөн асуугаад, нөгөө нь хариулах замаар өрнүүлээд байдаг. Тиймээс багш харилцан ярианы үед дээрх байдлыг анзаарч харах ба хэрэв аль нэг нь асуугаад, нөгөө нь хариулаад байгаа тохиолдолд яриаг зогсоож, дахин бэлтгүүлэх зэргээр ажиллаарай.</p>

Багшид зориулсан нэмэлт зөвлөмж:

Өмнөх ангиудад уншиж судалсан өгүүллэгээс илүү далайцтай, дэлхий дахины өргөн хүрээний асуудлыг хөндсөн юм уу, эсвэл хүний амьдралын утга учир, хүний хувь заяа, сэтгэл санааны олон янз байдлыг эргэцүүлсэн, үгийн тоо, хэлбэр хэмжээний хувьд ч томоохон гэж болох өгүүллэг болоод туужийг сонгож уншуулвал хүүхдийн сэтгэхүй ч тэлнэ. Хэрвээ хүүхдүүд хэт урт зохиолыг унших дуртай биш байвал багш нар зохиолыг бүрэлдэхүүн хэсгүүдэд хуваан, эвлүүлгийн аргаар уншуулж, харилцан бие биедээ ярьж өгөх байдлаар уншлагын хичээлийг зохион байгуулж болох юм. Ер нь багш анги танхимын нөхцөл болоод цагийн хязгаарыг урьдчилан тооцоолж, тусгай цаг гаргаж, сурагчдаараа зохиолыг бүрэн эхээр нь уншуулах тал дээр санаачлагатай ажиллахыг зөвлөж байна.

Зун ай

Намс намс гишгэх хос тогорууд нарлана. Намжаа цэнхэр дэлхий нүдээ нээсэн шиг цэнхэртэнэ. Зуны өглөө. Хундан цагаан хоньд хургаа дуудан, саамшина. Хойдох саахалтын эзэн хөөмийн эгшгээр уяраана. Хүүш хэцийн нууранд хээрийн галуу айлчлан ирж, гангар гунгар донгодно. Хөдөөний айлын гадуур хөгжилтэй болжморууд исгэрнэ.

Өндөр борхон бүсгүй өрхөө татан мишээнэ. Өехий цагаан банхар хаяанд нь тэгээд хуцна. Хар чулуутын энгэрт хулгар шар хошхирно. Зусландаа буусан айлууд зураг хуар шиг цайвартана. Зуузай холбосон хүлгүүд зул задран хурдална. Их үдийн наран илч төөнөн шараад их булгийн уснаас ундаална. Илчит цацрагийн туяа ээрэм талыг шатаана. Исгэрэн дуугарах царцаа энд тэндгүй дэвхэрнэ. Элэнц эмээгийн хөлс эгмээ даган урсана. Их нүдэн булаг эндхийн Чандмань эрдэнэ.

Шиврээ бороо шөнөжин шаагина. Сүүл сүүлдээ зүсрэн зүсрэн үргэлжилнэ. Сэмжин ухаа үүлс уулсыг хучин хэнэггүйтнэ. Саяхан хяргасан хоньд бөн бөн чичирнэ. Сиймхийгээр нь харин саарал боохой гэдэс гарна. Зүлгийн ногоо жигд өнгөөр тунарна.

Аяа, зуны бороо сая нэг онгос хийнэ.

Тэртээ хөхөлбий тэнгэрт наран мишээж туяарна. Түүний наахантай солонгын өнгө сацарна. Тогтох гуайн үрс хөөр баяр болон хөөцөлдөнө. Хөөрхий муу Дорлигийг “шар махтайг нь хатаасан даа, тэр хөөрхий минь их л зовсондоо. Хэд хоног эхлээр байсан хурга ишиг хэнэг ч үгүй хэвтэнэ. Харин тэднийг ялгаж хоёр тийш бэлчээнэ. Номин ногоон зүлгэн дээр өдөржин хариулна. Намхан буурал эмээгийн элгэн тараг санагдана. Саалин цаг болж хувин сав тачигнана. Саахалт айлын гадуур чимээ шуугиан ихэснэ. Холбож дууссан эрчүүд гэрийн зүг гэлдэрнэ. Хувин саваа савалзуулан эмээ, охид яарна. Оройн шаргал наран толгод дамнан хүүшилнэ. Оргилсон их ажил нэг өдөртөө дуусна.

Үдшийн гялаан, үүрийн цолмон тэртээд гялалзан гэрэлтэнэ. Өвгөд хөгшдийн шүтээн долоон бурхан сүүмэлзэнэ. Өлгийтэй бяцхан үр үнэгчлэн байж унтана. Үдшийн их бүрийгээр ширэглэн, ширэглэн, хурайлан хурайлан бүүвэйлнэ. Хөрш айлын шон дээр хоёр хүлэг үүрсэнэ хаяанд хэвтсэн хоточ “Хэн бэ” гэх шиг хуцна. Хайртаа хүлээсэн бүсгүйн хэнзхэн зүрх догдолно. Хүлээсэн, хүлээлгэсэн хоёр ингэж нэг уулзана. Хөхөө шувуу донгодон үүр тэмдэгрэхийг зарлана. Хүлэг нь эзгүй шон дээр хомоолын уур савсана. Хөгшин буурал эмээ өрхөө тэгээд татна. “Хүргэнтэй болох нь дээ, манайх” гэж “Гэгээн монгол”-оос эш татна.

Хар чулуутын жалга, судаг тэр чигээрээ ногоорно. Хээнцэр ялдамхан цэцэгс биесээ чимэн өнгөлөгтөнө. Хангайн чимэг буга, согоо хааяа хааяа урамдана. Хөглөгөр их уулсын модод шуугин шаагин намилзана. Хөөрхөн булцгар жимсгэнүүд хоног хоногоор хүрэлтэнэ. Хадат булгийн ус хоржигнон хүржигнэн долгилно. Зун ай. Зун аялгуу.

Боловсруулсан: Л.Цэдэнсодном